



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/439

Чингис хот

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.5, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд гаргасан газар эзэмших өргөдлийн дагуу 18 иргэнд автомашины гаражийн зориулалттай газрыг 15 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.
2. Иргэдийн эзэмшиж буй газрын хэмжээ баяршлыг хавсралтаар баталсугай.
3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.
4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зорилалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010725